

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/43

Арвайхээр

Ажлын хэсэг томилох тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай" 181 дүгээр тогтоол, Аймгийн Засаг даргын 2020 оны "Хөрөнгө зарцуулах тухай" А/516 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавирус /COVID-19/ цар тахлын өвчлөлөөс сэргийлэх, ажиглах, тусгаарлах бэлэн байдлын нөөцийн бэлэн байдлын хамгаалах хэрэгсэл, эм эмнэлгийн хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодис, байгууллагын шатахуун, тослох материал худалдан авалтын үнийн саналыг судлан гэрээ байгуулах эрх олгох ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Нөөцийн бэлэн байдлын хамгаалах хэрэгсэл, эм эмнэлгийн хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодис, шатахуун, тослох материалын үнийн саналыг судлан худалдан авалтын шууд гэрээ байгуулах ажлыг ажлын 3 хоногт багтаан шийдвэрлэхийг Удирдлага төлөвлөлтийн хэлтэс (Н.Оюунтуяа)-д даалгасугай.

3. Гэрээ шууд байгуулан нөөцийн бэлэн байдлын санхүүжилтийн асуудлыг Санхүү төрийн сангийн хэлтэстэй хамтран шийдвэрлэх, байгууллагын шатахуун, тос, тослох материалын зардлыг тээвэр шатахууны зардлаас санхүүжүүлэхийг тус тус нягтлан бодогч (Б.Валя)-д зөвшөөрсүгэй.


ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ

189000053

Эрүүл мэндийн газрын даргын 2020
оны 11 сарын 20 өдрийн 4 дугаар
тушаалын хавсралт



КОРОНОВИРУС /COVID-19/ ЦАР ТАХЛЫН ӨВЧЛӨЛӨӨС
СЭРГИЙЛЭХ ХҮРЭЭНД НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ ХУДАЛДАН
АВАЛТЫН ШУУД ГЭРЭЭ БАЙГУУЛАХ АЖЛЫН
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Н.Оюунтуяа Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга

Ю.Ичинноров-Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга

М.Золзаяа- Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга

Б.Валя- Нягтлан бодогч

М.Ганцэцэг – Гамшгийн үеийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн